



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өндөршил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/108/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Azure Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Зөвлөмж.....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.16 № 35

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 179,257.8 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулсан, акталсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 273,990.4 мянган төгрөгөөр буурчээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

4826050118

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	187,558,357.79	109,595,889.69
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	187,558,357.79	109,595,889.69
31210	Төгрөг	187,558,357.79	109,595,889.69
31211	Төрийн сангийн харилцах	186,402,078.54	109,595,889.69
31218	Ахмадын сангийн харилцах	1,156,279.25	-
33	АВЛАГА	144,327.26	1,109,079.25
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	279.25
33500	Бусад авлага	144,327.26	1,108,800.00
33510	Байгууллагаас авах авлага	144,327.26	864,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	244,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,616,752.33	64,036,232.13
35100	Түүхий эд материал	28,977,986.74	27,792,445.14
35110	Тусгай зориулалттай материал	28,977,986.74	27,792,445.14
35400	Хангамжийн материал	56,638,765.59	36,243,786.99
35410	Бичиг хэргийн материал	-	2,700.00
35420	Аж ахуйн материал	45,735,125.59	30,134,994.99
35450	Барилгын засварын материал	2,042,500.00	-
35460	Хүнсний материал	6,669,640.00	4,951,289.00
35470	Бусад хангамжийн материал	2,191,500.00	1,154,803.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	273,319,437.38	174,741,201.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,123,507,809.61	2,060,482,060.53
39200	Биет хөрөнгө	2,074,844,254.73	2,008,431,440.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,217,311,400.07	2,217,311,400.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(406,144,538.81)	(482,747,264.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,764,027.82	-
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(7,764,027.82)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	269,722,126.21	276,817,160.96
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(89,453,964.36)	(83,133,022.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,353,343.30	82,373,264.40
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(26,513,314.79)	(30,648,770.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,994,222.00	17,994,222.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(7,161,611.95)	(4,272,142.87)
39217	Номын фонд	14,736,593.06	14,736,593.06
39300	Биет бус хөрөнгө	48,663,554.88	52,050,620.00
39301	Программ хангамж	5,079,420.00	5,079,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(4,097,065.12)	(710,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,681,200.00	47,681,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,123,507,809.61	2,060,482,060.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,396,827,246.99	2,235,223,261.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,786,755.27	13,854,925.72
41300	Өглөг	26,786,755.27	13,854,925.72
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	441,300.00	462,125.00
41311	Цалингийн өглөг	441,300.00	-
41313	ХАОАТ-ын өглөг	-	462,125.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,114,800.00	-
413205	Тээвэр, шатахууны өглөг	532,200.00	-
413207	Албан томилолтын өглөг	3,928,000.00	-
413213	Бусад зардлын өглөг	654,600.00	-
41360	Бусад өглөг	21,230,655.27	13,392,800.72
41361	Байгууллагад төлөх өглөг	21,230,655.27	13,392,800.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	26,786,755.27	13,854,925.72
51	Засгийн газрын хувь оролцоо	2,370,040,491.72	2,221,368,335.88
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,300,831,913.70	1,300,831,913.70
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	1,300,831,913.70	1,300,831,913.70
51200	Хуримтлагдсан үр дүн	364,406,529.30	215,734,373.46
51210	Өмнөх үеийн үр дүн	364,406,529.30	364,406,529.30

51220	Тайлант үеийн үр дүн	-	(148,672,155.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	704,802,048.72	704,802,048.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,370,040,491.72	2,221,368,335.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,396,827,246.99	2,235,223,261.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,420,962,900.00	1,423,786,600.00
1310	Улсын төсвөөс	1,276,891,100.00	1,272,790,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,276,891,100.00	1,272,790,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	144,071,800.00	150,996,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	144,071,800.00	150,996,500.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	358,466,863.44	123,427,643.74
1200	Нийтлэг татварын бус орлого	358,466,863.44	123,427,643.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,043,443.00	9,860,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	10,043,443.00	9,860,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	345,297,860.44	108,496,583.74
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	3,125,560.00	5,071,060.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,779,429,763.44	1,547,214,243.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,407,580,231.92	1,687,029,012.56
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,378,790,722.43	1,656,413,307.45
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	902,833,757.00	1,082,091,586.00
210101	Үндсэн цалин	612,416,832.00	645,674,642.00
210102	Нэмэгдэл	259,132,265.00	353,194,404.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	38,680,000.00
210104	Урамшуулал	31,284,660.00	44,542,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,058,912.75	128,677,982.06
210201	Тэтгэврийн даатгал	75,102,064.32	87,957,646.36
210202	Тэтгэмжийн даатгал	8,900,323.20	10,826,926.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,446,561.60	5,413,463.86
210204	Ажилгүйдлийн даатгал	4,152,290.60	4,981,181.47
210205	Эрүүл мэндийн даатгал	16,457,673.03	19,498,763.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,652,638.25	136,432,829.15
210301	Гэрэл, цахилгаан	10,575,423.25	13,386,204.15
210302	Түлш, халаалт	121,561,115.00	121,561,825.00
210303	Цэвэр, бохир ус	516,100.00	1,484,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,685,300.00	37,880,780.60
210401	Бичиг хэрэг	1,334,300.00	1,833,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,788,700.00	9,273,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,562,300.00	21,268,709.50
210408	Бараа материал акталсны зардал	-	5,504,971.10
2105	Нормативт зардал	36,541,580.00	37,798,981.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	735,400.00
210502	Хоол, хүнс	36,541,580.00	37,063,581.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,147,000.00	10,517,700.00
210604	Урсгал засвар	2,147,000.00	10,517,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,910,731.27	10,891,836.24
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,910,731.27	10,891,836.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,960,803.16	212,121,612.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,595,165.00	29,645,725.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	5,863,696.00	8,611,641.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	162,501,942.16	173,864,245.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,789,509.49	30,615,705.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,646,590.00	24,927,307.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,685,590.00	24,927,307.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,961,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	142,919.49	5,688,398.11

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,919.49	5,688,398.11
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,407,580,231.92	1,687,029,012.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	371,849,531.52	(139,814,768.82)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	3,875,593.26	8,857,387.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,875,593.26	8,857,387.02
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3,875,593.26	8,857,387.02
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	367,973,938.26	(148,672,155.84)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,420,962,900.00	1,423,786,600.00
1310	Улсын төсвөөс	1,276,891,100.00	1,272,790,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,276,891,100.00	1,272,790,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	144,071,800.00	150,996,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	144,071,800.00	150,996,500.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	12,023,443.00	10,032,800.00
1200	Нийтлэг татварын бус орлого	12,023,443.00	10,032,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,023,443.00	10,032,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	12,023,443.00	10,032,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,432,986,343.00	1,433,819,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,268,648,631.02	1,508,156,568.10
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,239,857,101.53	1,469,143,870.74
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	899,150,532.00	1,082,070,747.20
210101	Үндсэн цалин	621,667,491.00	600,107,230.30
210102	Нэмэгдэл	245,902,921.00	397,203,656.90
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	38,680,000.00
210104	Урамшуулал	31,580,120.00	46,079,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,058,912.75	128,677,995.86
210201	Тэтгэврийн даатгал	75,102,064.32	87,736,233.61
210202	Тэтгэмжийн даатгал	8,900,323.20	10,437,470.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,446,561.60	5,215,680.90
210204	Ажилгүйдлийн даатгал	4,152,290.60	5,064,588.95
210205	Эрүүл мэндийн даатгал	16,457,673.03	20,224,021.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,228,880.51	136,776,901.89
210301	Гэрэл, цахилгаан	10,719,750.51	13,241,876.89
210302	Түлш, халаалт	131,070,330.00	121,561,825.00
210303	Цэвэр, бохир ус	438,800.00	1,973,200.00
2105	Нормативт зардал	37,371,690.00	35,215,230.00
210502	Хоол, хүнс	37,371,690.00	35,215,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200,000.00	9,434,000.00
210604	Урсгал засвар	5,200,000.00	9,434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,335,231.27	19,831,752.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	329,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,335,231.27	19,501,952.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,511,855.00	57,137,243.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,042,455.00	50,296,743.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	5,469,400.00	6,840,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,791,529.49	39,012,697.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,648,610.00	33,324,020.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,687,610.00	33,324,020.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,961,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	142,919.49	5,688,398.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,919.49	5,688,398.11

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	279.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	279.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,268,648,631.02	1,508,156,568.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	164,337,711.98	(74,337,168.10)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,250,868.73	3,625,300.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	15,250,868.73	3,625,300.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	15,250,868.73	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,250,868.73	3,625,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,250,868.73	3,625,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(15,250,868.73)	(3,625,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	149,086,843.25	(77,962,468.10)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,471,514.54	187,558,357.79
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,558,357.79	109,595,889.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	(3,567,408.96)	2,002,066,553.46
Тайлант үеийн үр дүн	-	-	367,973,938.26	367,973,938.26
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	364,406,529.30	2,370,040,491.72
Тайлант үеийн үр дүн	-	-	(148,672,155.84)	(148,672,155.84)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,831,913.70	704,802,048.72	215,734,373.46	2,221,368,335.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/
			Зөрүү
Татаас, санхүүжилтийн орлого	1,613,548,100.00	1,433,819,400.00	179,728,700.00
Улсын төсвөөс	1,460,551,600.00	1,281,920,100.00	178,631,500.00
Орон нутгийн төсвөөс	152,996,500.00	151,899,300.00	1,097,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,613,548,100.00	1,433,819,400.00	178,631,500.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,262,033,700.00	1,210,748,743.06	51,284,956.94
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,121,397,800.00	1,082,070,747.20	39,327,052.80
Цалин	1,121,397,800.00	1,082,070,747.20	39,327,052.80
Нийгмийн хамгааллын шимтгэл	140,635,900.00	128,677,995.86	11,957,904.14
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	140,635,900.00	128,677,995.86	11,957,904.14
Бараа, үйлчилгээний урсгал зардал	351,514,400.00	299,876,845.79	51,637,554.21
Гэрэл цахилгааны зардал	20,000,000.00	13,241,876.89	6,758,123.11
Түлш, халаалтын зардал	121,562,500.00	121,561,825.00	675.00
Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	1,973,200.00	26,800.00
Хоол	74,704,300.00	35,215,230.00	39,489,070.00
Бусад бараа үйлчилгээний зардал	82,348,900.00	72,597,795.79	9,751,104.21
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6,840,600.00	6,840,500.00	100.00
Урсгал засварын зардал	9,434,000.00	9,434,000.00	-
Бусад /үдийн цай/	34,624,100.00	33,324,020.00	1,300,080.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,613,548,100.00	1,510,625,588.85	102,922,511.15

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		186,402,078.54	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		109,595,889.69	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,162.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10,162.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 4 ажил гүйлгээ бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.7-т (*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж ажиллах.

Илрүүлэлт 2: Үндсэн хөрөнгийн түүвэр тооллого хийхэд 3 ширхэг хөрөнгийн коджуулалт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 20 дугаар зүйлийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;*) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн ашиглалт хадгалалтад хяналт тавьж ажиллах, хөрөнгийн коджуулалт хийх.

Илрүүлэлт 3: Санхүүгийн тайлан, Хандив тусламжийн орлого, Хандив тусламжийн зарцуулалтын тайлан, гэсэн 3 мэдээлэл 6 дугаар сард, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн мэдээллийг 2025 оны 1 дүгээр сард Шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т (*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална*), 4.1.3-т (*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*); гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж ажиллах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100 хувийг залруулагдаагүй алдаа, зөрчил эзэлж байна. Нийт 10,162.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь 3,591.1 мянган төгрөгийн нийцлийн аудитын зөрчил, 6,571.5 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 6,571.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 10,298.7 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 4 ажил гүйлгээ бүртгэлд тусгасан байна.	1	6,571.5	-	-	-	-	1	6,571.5	-	-
Дүн	1	6,571.5	-	-	-	-	1	6,571.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль										
Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 3 ширхэг хөрөнгийн коджуулалт хийгдээгүй байна.	1	3,591.1	-	-	-	-	1	3,591.1	-	-
Шилэн дансны тухай хууль										
Санхүүгийн тайлан, Хандив тусламжийн орлого, Хандив тусламжийн зарцуулалтын тайлан гэсэн 3 мэдээлэл 6 дугаар сард, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн мэдээллийг 2025 оны 1 дүгээр сард Шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дүн	2	3,591.1	-	-	-	-	2	3,591.1	-	-